

## НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРЭГ



# ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ













/Албан ёсны статистик мэдээллээр бэлтгэв./



2016 оны 11-р сар

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	3
 АЖ ҮЙЛДВЭР	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	5
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	6
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	7
 ЭРҮҮЛ МЭНД , ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	8-9
 МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО	9
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	10
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	11
 ГЭМТ ХЭРЭГ	11-12



**ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ  
ЖИЛ БҮРИЙН 11-Р САРЫН БАЙДЛААР**

Үзүүлэлт / он	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016
Суурин хүн ам, жилийн эцэст	Хүн	33234	34547	35813	-
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	869	861	861	804
Ажилгүйдчүүд, сарын эцэст	Хүн	1306	1094	948	907
үүнээс : эмэгтэй	Хүн	736	605	710	477
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	Тоо	239	158	258	408
Бүртгэсэн гэмт хэрэг	Тоо	285	312	396	460
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	13183.5	14449.0	14068.3	16258.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	12854.2	13923.9	13775.8	15691.4

Дүүргийн төсөөт эхний 11 сарын байдлаар 918.9 сая төгрөгийн татварын орлого орж, төлөвлөгөө 6.3 сая төгрөгөөр буюу 0.7%-иар өссөн байна.

Татварын орлогын 20,4%-ийг хүн амын орлогын албан татвар, 28,5%-ийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 8,1%-ийг бууны татвар, 1,3%-ийг ус ашигласны төлбөр, 1,0%-ийг түгээмэл тархацтай амнат, 11,6%-ийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 29,1%-ийг хүү торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

**Нийслэлийн дүүргүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын харьцуулсан үзүүлэлт:**

	Хэмжих Нэгж	2015 оны 11-р сарын байдлаар				2016 оны 11-р сарын байдлаар					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	287	Баянгол	7253	Налайх	52	293	Баянгол	7155	Налайх	53
			Чингэлтэй	1834	Багануур	47		Чингэлтэй	1779	Багануур	47
			Сүхбаатар	672	Багахангай	29		Сүхбаатар	674	Багахангай	30
Ажилгүйдчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	01000**	136	Багахангай	473	Баянгол	95	139	Багахангай	501	Сонгино-хайрхан	113
			Налайх	434	Сонгинохайрхан	87		Налайх	414	Баянгол	111
			Багануур	283	Баянзүрх	80		Багануур	287	Баянзүрх	107
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0100*	14	Багахангай	15	Багануур	10	15	Налайх	22	Хан-Уул	9
			Налайх	14	Баянгол	9		Багануур	21	Баянгол	9
			Сонгино-хайрхан	13	Хан-Уул	9		Баянзүрх	15	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	01000	291	Баянзүрх	319	Хан-Уул	224	283	Баянзүрх	325	Сүхбаатар	228
			Чингэлтэй	263	Багануур	191		Багануур	270	Хан-Уул	222
			Сонгино-хайрхан	258	Багахангай	83		Чингэлтэй	256	Багахангай	65
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	мян.төг	96	Сүхбаатар	119	Багануур	83	96	Чингэлтэй	114	Багануур	78
			Чингэлтэй	116	Налайх	76		Сүхбаатар	113	Налайх	75
			Хан-Уул	115	Багахангай	68		Хан-Уул	111	Багахангай	65
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	181	Сүхбаатар	293	Багануур	148	187	Сүхбаатар	292	Багануур	147
			Чингэлтэй	189	Хан-Уул	132		Баянгол	212	Сонгино-хайрхан	132
			Баянгол	183	Багахангай	82		Чингэлтэй	212	Багахангай	79



**ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ**

Түүхий эдийн нэр	2014	2015	2016
	11-р сар	11-р сар	11-р сар
Тэмээний шир	20000	22000	15000
Адууны шир	37000	42000	30000
Үхрийн шир	52000	30000	35000
Хонины арьс	6000	2000	2000
Ямааны арьс /ноолууртай/	15000	12000	17000



Түүхий эдийн үнэ, өмнөх оны мөн үеэс тэмээний шир 7000 төгрөгөөр буюу 31,8%, адууны шир 12000 төгрөгөөр буюу 28,6%-иар тус тус буурч, үхрийн шир 5000 төгрөгөөр буюу 16,7%, ямааны ноолууртай арьс 5000 төгрөгөөр буюу 41,7%-иар өсч, хонины арьс мөн үеийн түвшинд байна.

**Түлшний үнэ, төгрөгөөр:**

Байршил	Түлшний мод шуудай / 6-7 кг/		Нүүрс -Налайх /12-14кг/
	Хар мод /6-7 кг/	Нарс мод	
Налайх	2000		3000
Чингэлтэй	1800		3000
Сүхбаатар	2000		3000
Цайз зах	1800		3000
Хангай зах	1800	1500	3000
Дундаж үнэ	1880	1500	3000


**Шатахууны үнэ -1 литр /төгрөгөөр/:**

ААН-ийн нэр	2015.11 сар					2016.11 сар				
	Au 95	Au 80	Au 92	Дизель түлш	Газ	Au 95	Au 80	Au 92	Дизель түлш	Газ
“Жаст Ойл” ХХК	1890	1550	1660	1790		1730		1530	1640	
“Петровис” ХХК	1890	1550	1660	1790		1730	1450	1530	1640	
“Магнай трейд” ХХК	1890	1550	1660	1790		1730	1450	1530	1640	
“Сод Монгол” ХХК	1890		1660	1790		1730		1550	1640	
“Шунхлай” ХХК		1550	1660	1790			1450	1530	1640	
“ЮниГаз” ХХК					1100					900
<b>Дундаж үнэ</b>	<b>1890</b>	<b>1550</b>	<b>1660</b>	<b>1790</b>	<b>1100</b>	<b>1730</b>	<b>1450</b>	<b>1534</b>	<b>1640</b>	<b>900</b>



**АЖ ҮЙЛДВЭР**

Үзүүлэлт / он	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэл /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэл /үнийн дүнгээр, сая төгрөгөөр/		
		2014	2015	2016	2014	2015	2016
<b>Эрчим хүчний үйлдвэр</b>							
Цахилгаан	сая.квт.цаг	96.29	102.0	111.3	11581.7	14146.7	17044.7
Дулаан	мян.Гкал	102.3	95.9	99.3	1851.3	2274.9	2388.1
Усан хангамж	мян.м3	1419.9	1183.5	1169.0	440.1	464.6	790.9
<b>Олборлох үйлдвэр</b>							
Шохой	тонн	39.3	39.9	41.6	393.2	399.6	392.1
Нүүрс	мян.тн	4.4	5.4	3.5	181.2	216.4	168.0
Хайрга	мян.м3	-	7	7.0	0	117.4	128.6
Элс	мян.м3	45.8	31.2	14.3	325.1	211.3	94.1
<b>Боловсруулах үйлдвэр</b>							
Тоосго	мян.ш	20719.0	22063.0	13137.0	3115.9	2592.7	1245.4
Цемент	мян.тн	37.4	30.1	28.6	5629.4	4074.9	3890.9
Талх	мян.ш	20.8	17.6	5.3	19.5	16.5	4.9
Оёдол	мян.ш	8.4	9.4	9.4	59.0	47.0	428.1



2016 оны эхний 11 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 9.1%, дулаан 3.5%, шохой 4.2%-иар тус тус өсч, усан хангамж 1.2%, нүүрс 35.2%, элс 54.2%, тоосго 40.4%, цемент 4.9%, талх 69.9%, оёдол иар тус тус буурсан байна. Хайрганы олборлолт, оёдлын үйлдвэрлэл мөн үеийн түвшинд байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 20.5%, дулаан 4.9%, усан хангамж 70.2%, хайрга 9.5%, оёдол 10 дахин өссөн байна. Харин шохой 1.8%, нүүрс 22.4%, элс 55.4%, тоосго 51.9%, цемент 4.5%, талх 70.3%-иар тус тус буурсан байна.




## НИЙГМИЙН ДААТГАЛ

2016 оны эхний 11 сард нийгмийн даатгалын үйлчилгээнд 7461.99 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн орлого оржээ.

Нийт шимтгэл төлөгчдийн 40.5 хувь буюу 3020.8 сая төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллага, 47.2 хувь буюу 3519.6 сая төгрөг нь төсөвт байгууллага, 1.6 хувь буюу 115.7 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгал, 0.8 хувь буюу 64.9 сая төгрөг нь үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах, 4.8 хувь буюу 358.8 сая төгрөг нь нөхөн шимтгэл, сайн дурын даатгуулагчдых, 5.1 хувь буюу 382.1 сая төгрөг нь эрүүл мэндийн төр хариуцаж байна.

Нийгмийн даатгалын сангаас эхний 11 сард 124705 даатгуулагч иргэнд 20091,3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Даатгалын сангийн зарлага:



Нийт зардлын 72,7 хувийг тэтгэвэр, 12,5 хувийг ҮОМШӨ, 3,0 хувийг тэтгэмж, 1,2 хувийг ажилгүйдэл, 10,6 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо эхний 11 сард 45119, олгосон тэтгэврийн хэмжээ 14610,4 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 68,1 хувийг өндөр насны, 13,2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 5,1 хувийг тэжээгчээ алдсан, 13,6 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2016 оны 11-р сард давхардсан тоогоор нийт 3514 хүнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлсний зардал өссөн дүнгээр 3055.7 сая төгрөг байна.

Үзүүлэлтүүд	2015		2016	
	Хүний тоо /сард/	Дүн /мян.төг/	Хүний тоо /сард/	Дүн /мян.төг/
Халамжийн орлого /бүгд/	-	<b>2852193.7</b>	-	<b>3233380.0</b>
Зарцуулалт бүгд	11317	<b>2749181.0</b>	<b>3514</b>	<b>3055707.8</b>
Үүнээс: Халамжийн тэтгэвэр	899	1088890.3	851	1186387.7
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	540	363889.9	541	469580.7
Ахмад настны хөнгөлөлт	3602	203990.4	70	236886.2
Халамжийн үйлчилгээ	216	87644.0	1034	84260.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	467	70367.0	47	72531.7
Эхчүүдийн мөнгөн тэтгэмж	988	409440.3	932	392689.3
Алдарт эхийн одонгийн тусламж	2607	344540.0	1	346860.0
Алдар цолтой ахмадуудад	10	19018.2	10	16514.2
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	1939	149815.0		220187.5
Амьжиргааг дэмжих зөвлөл	49	7978.5	28	6296.4
ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-	-	-	14980.6
Судалгааны зардал	-	-	-	6700.0
Бусад зардал	-	3607.4	-	1833.5



## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 907 хүн байгаагийн 52,5 хувь нь эмэгтэйчүүд, үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,3%-аар буюу 41 хүнээр буурсан байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 13,1 хувь нь 15-24 насныхан, 35,9 хувь нь 25-34 насныхан 24,6 хувь нь 35-44 насныхан, 18,1 хувь нь 45-54 насныхан, 4,7 хувь нь 55-59 насныхан, 3,6 хувь нь 60-аас дээш насныхан байна.

Үзүүлэлт/он		2014	2015	2016
Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд		1094	948	907
-эмэгтэй		605	710	477
<b>15-24</b>	<b>Бүгд</b>	<b>211</b>	<b>156</b>	<b>119</b>
насны	-эмэгтэй	116	99	62
<b>25-34</b>	<b>Бүгд</b>	<b>362</b>	<b>356</b>	<b>326</b>
насны	- эмэгтэй	213	274	173
<b>35-44</b>	<b>Бүгд</b>	<b>263</b>	<b>227</b>	<b>223</b>
насны	- эмэгтэй	138	181	118
<b>45-54</b>	<b>Бүгд</b>	<b>186</b>	<b>161</b>	<b>164</b>
насны	-эмэгтэй	105	118	118
<b>55-59</b>	<b>Бүгд</b>	<b>50</b>	<b>34</b>	<b>43</b>
насны	-эмэгтэй	24	26	23
<b>60+</b>	<b>Бүгд</b>	<b>22</b>	<b>14</b>	<b>32</b>
насны	-эмэгтэй	9	12	14
<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд</b>		<b>35</b>	<b>22</b>	<b>37</b>

Ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 0,3%-ийг магистр доктор, 15,1%-ийг дипломын болон бакалаврын дээд, 8,1%-ийг тусгай мэргэжлийн дунд, 10,1%-ийг техникийн болон мэргэжлийн, 52,2%-ийг бүрэн дунд мэргэжил, 9,5%-ийг суурь боловсрол, 2,6%-ийг бага боловсрол, 2,1%-ийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Боловсролын түвшнээр:

Үзүүлэлт	2014	2015	2016
Магистр, доктор	2	2	3
Дипломын болон бакалаврын дээд	171	176	137
Тусгай мэргэжлийн дунд	54	63	74
Техникийн болон мэргэжлийн	126	103	92
Бүрэн дунд	542	486	474
Суурь	146	90	84
Бага боловсрол	35	22	24
Боловсролгүй	18	6	19
<b>ДҮН</b>	<b>1094</b>	<b>948</b>	<b>907</b>



## СОЁЛ УРЛАГ

Соёл, урлагийн байгууллага нь эхний 11 сард 7 төрлийн 104 ажил, үйлчилгээ явуулж 6489.7 мян.төгрөгийн орлоготой ажилласан байна.

Ажил, үйлчилгээ	Үүнээс:						
	Урлагийн тоглолт	Хурал, цуглаан	Кино, үзвэр	Уралдаан, тэмцээн	Дугуйлан, сургалт	Номын сан /хүн/	Музейн үзвэр /хүн/
	19	50	20	9	6	2574	511



## ЭРҮҮЛ МЭНД

### Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл:

Үзүүлэлт / он	2014	2015	2016
Төрсөн эхийн тоо	904	934	782
Амьд төрсөн хүүхэд	907	937	784
Амьгүй төрсөн	2	7	6
Эхийн эндэгдэл	2	-	-
Нас баралт	212	214	208
Үүнээс: -1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	16	12	17
Эмнэлгийн нас баралт	16	20	32
Гэрийн нас баралт	174	160	149
Улаанбаатар хотод нас барсан	22	34	27

Эхний 11 сарын байдлаар төрсөн эхийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 16.3%-аар, нас баралт 2.8%-аар тус тус буурсан байна.

Нийт нас баралтын 71,6%-ийг гэрийн, 12,9%-ийг Улаанбаатар хот, 15,5%-ийг эмнэлгийн нас баралт эзэлж байна.

### Халдварт өвчин:

Үзүүлэлтүүд	2014	2015	2016
<b>Халдварт өвчин</b>	<b>158</b>	<b>258</b>	<b>408</b>
- халдварт шар	8	5	7
-менингет	3	-	-
- салхин цэцэг	88	53	31
- гахайн хавдар	3	3	1
- ёлом	-	3	-
-бруцеллез	-	-	1
-дизентери	8	8	2
-ГХА өвчин	39	7	44
-хоолны хордлого	2	1	6
-сальмонеллэз	5	2	3
-Улаан бурхан	-	169	304
-улаан эсэргэнэ	1	5	4
-эритема	-	-	1
-нярайн бактер үжил	-	1	-
-хачигт риккеттиоз	1	1	2
- 6 дахь өвчин	-	-	2
<b>Сүрьеэ</b>	<b>59</b>	<b>48</b>	<b>60</b>
<b>Арьс өнгөний өвчин</b>	<b>327</b>	<b>519</b>	<b>345</b>
-тэмбүү	122	135	85
- Үүнээс төрөлхийн тэмбүү	-	1	1
-Заг хүйтэн	23	51	57
-Хамуу	4	2	-
-Бэлгийн замын мөөгөнцөр	87	226	80
-Мөөгөнцөр	24	23	15
-Трихомониаз	67	82	117

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд халдварт өвчнөөр 408 хүн өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 58,1%-аар өсч, арьс өнгөний өвчлөл 345 гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33,5%-иар буурсан байна. Сүрьеэгээр 60 хүн өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25,0%-аар өссөн үзүүлэлттэй байна.



**Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт:**

Үзүүлэлт / он	2014	2015	2016
Урьдчилан сэргийлэх тарилга	6938	5853	6722
Амбулаторын үзлэг	185717	176621	177294
Ор хоног	42303	39728	42210
Эмчийн тоо	68	72	69
Сувилагчийн тоо	102	104	104
Орны тоо	165	165	177

Амбулаторийн үзлэгийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 1%-иар, ор хоног 6.1%-аар, урьдчилан сэргийлэх тарилга 15.6%-иар тус тус буурсан байна.

**ИРГЭНИЙ БҮРТГЭЛ**

**Төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл цуцлалт, үрчлэлтийн бүртгэл:**

Төрсөн хүүхэд- Бүгд		2014	2015	2016
		861	861	804
Үүнээс:	-эрэгтэй	448	433	405
	-эмэгтэй	413	428	399
<b>Нас баралт -Бүгд</b>		<b>218</b>	<b>242</b>	<b>231</b>
Үүнээс:	-эрэгтэй	125	150	150
	-эмэгтэй	93	92	81

2016 оны эхний 11 сард 804 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 231 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 175 гэрлэлтийг бүртгэж, 56 гэр бүлийг цуцалсан байна.

Төрсөн хүүхдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6%-иар буурсан байна.

Харин нас баралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 11 буюу 4,5%-аар

буурсан байна.

**Бүртгүүлсэн гэр бүл:**

Бүгд	2014		2015		2016		
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	
		174	174	167	167	175	175
Насны бүлгээр	18-19	1	3	2	6	0	3
	20-24	45	69	46	54	39	55
	25-29	70	53	63	60	74	62
	30-34	21	18	24	23	29	24
	35-39	18	14	15	13	16	13
	40-44	10	10	10	6	6	11
	45-49	4	3	5	3	6	2
50, +	5	4	2	2	5	5	

Нийт бүртгүүлсэн 175 гэр бүлийг насаар нь ангилбал, 0,9% нь 18-19 насны, 26,8% нь 20-24 насны, 38,8% нь 25-29 насны, 15,1% нь 30-34 насны, 8,4% нь 35-39 насны, 4,8% нь 40-44 насны, 5,2% нь 45-с дээш насныхан байна.

Нийт бүртгүүлсэн 175 гэр бүлийг ханилсан жилээр нь авч үзвэл, 4 хос буюу

2,3% тайлант онд гэр бүл болсон, 36 хос буюу 20,6% нь жилийн өмнө, 44 хос буюу 25,1% нь 2-3 жилийн өмнө, 91 хос буюу 52,0% нь 4 ба түүнээс дээш жилийн өмнө гэрлэсэн хосууд байна.

Бүртгүүлсэн хосуудыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,7%-иар өссөн байна.

**Гэр бүл цуцлалт:**

		2014	2015	2016
<b>БҮГД</b>		<b>47</b>	<b>40</b>	<b>56</b>
Гэр бүл байсан хугацаагаар /жилээр/	1 хүртэл	-	2	1
	1-3	2	4	4
	4-6	16	5	6
	7-9	7	16	13
	10-14	4	3	15
	15-19	8	5	3
	20 ба дээш	10	5	14

Нийт 56 гэр бүлийн цуцлалт байгааг гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал 1,8% нь 1 жил, 7,1% нь 1-3 жил, 10,8% нь 4-6 жил, 23,2% нь 7-9 жил, 26,8% нь 10-14 жил, 5,3% нь 15-19 жил, 25,0% нь 20-с дээш жил ханилсан хосууд байна.

Гэр бүл цуцлалт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40,0%-иар өссөн байна.

**Үрчлэлт:**

		2014	2015	2016
БҮГД		16	12	12
насаар	3 хүртэл	10	5	5
	3-6	3	2	2
	7-9	1	1	1
	10 ба дээш	2	4	4

2016 оны эхний 11 сард 12 хүүхэд үрчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.




**МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО**

Холбооны байгууллага 189259.5 мянган төгрөгний орлоготой ажиллаж, үүний 92727.2 мянган төгрөг буюу 49.0% нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна. Харин телефон цэгийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7%-аар буурсан байна. Нийт суурин телефон цэгийн 320 буюу 57.7%-ийг айл өрх, 169 буюу 30.5%-ийг төсвийн байгууллага, 65 буюу 11.8%-ийг бизнесийн байгууллагууд ашиглаж байна.

Үзүүлэлт / он	Хэмжих нэгж	2014	2015	2016
Нийт орлого	мян.төг	164021.1	173642.2	189259.5
Үүнээс: - хүн амаас	мян.төг	83650.8	85084.7	92727.2
Телефон цэг	тоо	678	558	554
Үүнээс: - айл өрх	тоо	412	332	320
Интернетийн үйлчилгээний цэг	тоо	2	2	2
Интернетийн үйлчилгээний суудлын тоо	тоо	20	20	20
Интернетээр үйлчлүүлэгчийн тоо	тоо	19500	18200	11844
Интернетийн байнгын хэрэглэгчдийн тоо	тоо	257	191	293
Таксфон	тоо	1	1	1

**Суурин телефон цэгийн тоо**



**Кабелийн телевиз:**

Үзүүлэлт / он	Хэмжих нэгж	2015	2016
<b>КТВ-ийн орлого</b>	мян.төг	<b>71985.2</b>	<b>261309.8</b>
“Тана долгио” ХХК	мян.төг	17945.2	32136.5
Хэрэглэгч	тоо	1500	3333
“Болор утас” ХХК	мян.төг	54040.0	229173.3
Хэрэглэгч	тоо	3490	3575

Эхний 11 сарын байдлаар кабелийн телевизүүдийн хэрэглэгчийн тоо 6908, орлого 261309.8 мянган төгрөг болсон байна.



## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

### Хот тохижилт:

Үзүүлэлт	2016 он	Үүнээс:		
		Орон сууцны	Гэр хороолол	ААН
Нийт орлого /мян.төг/	251097.1	88631.5	108110.0	54335.0
Хог тээвэрлэлт /мян.тн/	43.6	7.3	29.0	7.3

2016 оны эхний 11 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 251.1 сая төгрөг болж, орлогын 35.3%-ийг орон сууц, 43.0%-ийг гэр хороолол, 21.6%-ийг аж ахуйн нэгжийн орлого эзэлж байгаа ба нийт 53.6 мян.тн хог тээвэрлэсэн байна.

### Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ :

Үзүүлэлт / он	Хэмжих нэгж	2015	2016
<b>Шахсан ус</b>	<b>мян.м3</b>	<b>1179.0</b>	<b>1114.6</b>
<b>Борлуулсан ус</b>	<b>мян.м3</b>	<b>568.9</b>	<b>523.0</b>
-Хүн ам	мян.м3	311.1	261.6
-Аж ахуйн нэгж	мян.м3	257.8	261.4
<b>Татан зайлуулсан бохир</b>	<b>мян.м3</b>	<b>422.2</b>	<b>333.2</b>
Ус борлуулалтын орлого	сая.төг	705.9	861.5
Сувагжуулалтын орлого	сая.төг	318.7	300.3
Халаалтын орлого	сая.төг	146.4	228.7

2016 оны эхний 12 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 523.0 мян.м3 ус борлуулснаас, 261.6 мян.м3 усыг хүн амд, 262.4 мян.м3 усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.



## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс эхний 11 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж нийт 766 айл өрх, 445 аж ахуйн нэгж, байгууллагаас 2297 зөрчил илрүүлэн, 275 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 73, мэдэгдэл 178 ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 57-г хүргүүлсэн байна.

Мөн объектын гал түймрийн 96 дуудлагаар ажиллаж, 507.0 сая төгрөгийн өмч хөрөнгө авран хамгаалсан байна.

Нийт гал түймрийн 96 дуудлага ирснээс төрийн өмчийн 13, аж ахуйн нэгж байгууллагын 10, хувийн өмчийн 71, хамтын болон гадаадын улсын өмчийн 2 дуудлага байна. Нийт 96 гал түймрийн цахилгааны буруугаас 17, пийшин зуух яндангийн цонолтоос 18, ил задгай гал, асгасан нурамаас 37, машин техник гэмтэл ашиглалт буруугаас 5, шалтгаан тогтоогдоогүй 15 гал түймэр, бусад шалтгаантай 4 гал гарсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

Үзүүлэлт /он		2014	2015	2016
Гарсан гэмт хэрэг бүгд		312	396	460
-Хүн амины	Санаатай	8	6	3
	Учрал	9	3	7
	Бусдыг болгоомжгүй алах	-	1	-
-Хүчин		6	3	5
-Дээрэм		3	3	2
-Танхай		10	11	15
-Хулгай	Иргэдийн өмчийн	47	76	131
	Малын	7	11	8
	ААН, байгууллагын	9	1	2
-Булаалт		1	1	1
-Залилан		5	11	14
-ББМБГУ		133	166	181
-Авто тээвэр		23	24	27
-Бусад		51	79	64
Илрээгүй хэрэг		21	30	44
<b>Илрүүлэлтийн хувь</b>		<b>74.1</b>	<b>72.5</b>	<b>74.9</b>
Гэмт хэрэгт холбогдогчид		306	392	455
Үүнээс:	-ажилгүй	176	248	322
	-албан хаагч	23	26	26
	-сурагч	10	6	12
	-оюутан	9	12	6
	-малчин	6	9	2
	-тэнэмэл	-	2	-
	- төрийн бус байгууллагын ажилтан	3	3	3
	-сургууль завсардсан	2	-	-
	- цэргийн албан хаагч	1	-	1
	-ХХЭрхлэгч болон хувийн хэвшил	76	86	83
Эрүүлжигдсэн хүн		3490	3333	2743


Дүүрэгт 2016 оны эхний 11 сард 460 гэмт хэрэг гарсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 64 буюу 16.2%-аар өсч, хэргийн илрүүлэлт 74.9%-тай байна.

Дээрх 460 гэмт хэрэгт 355 сэжигтэн яллагдагч холбогдсон ба насны байдлаар авч үзвэл: 15 хүртэлх насны 3, 16-17 насны 27, 18-24 насны 88, 25-29 насны 117, 30-34 насны 69, 35-39 насны 53, 40-44 насны 46, 45-49 насны 27, 50-54 насны 14, 55-59 насны 7, 60-64 насны 2, 65-69 насны 2 хүн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 788.7 сая төгрөгийн хохирол учирснаас 448.1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, нас барсан 26 хүн, гэмтсэн 249 хүн байна.

2016 оны эхний 11 сард 14307 зөрчил илрүүлж, 13273 хүнийг 502.4 сая төгрөгөөр торгож, 2743 хүнийг эрүүлжүүлж, 10 хүнийг архины албадан эмчилгээнд явуулж, 510 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 170 хүнийг шүүхээр баривчлуулан ажилласан байна.

Гэмт хэргийн байдлыг хороодоор харуулбал:



2016 оны эхний 11 сард дүүрэгт гарсан гэмт хэргийн 100 нь 1-р хороонд, 110 нь 2-р хороонд, 67 нь 3-р хороонд, 46 нь 4-р хороонд, 28 нь 5-р хороонд, 62 нь 6-р хороонд, 47 нь 7-р хороонд тус тус гарсан байна.

#### Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утсаар гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2016 оны эхний 11 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 80 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Санал, хүсэлт, өргөдлийн 68-д хариу өгч, 12-д хариу өгөх хугацаа болоогүй судлагдаж байгаа ба шийдвэрлэлт 85.0 хувьтай байна. Ирсэн өргөдөл гомдол саналын 72.7% нь бичгээр, 22.1% нь утсаар, 5.2% нь дээд байгууллагаас ирсэн байна.

Хотын Захирагчийн Ажлын Албанд нийт 279 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авснаас 79 санал гомдлыг утсаар, 200 санал хүсэлт өргөдлийг бичгээр хүлээж авсан байна. Санал хүсэлт өргөдлийн 86,7 хувь буюу 242 санал хүсэлт өргөдлийг шийдвэрлэсэн. Шийдвэрлэх шатанд хугацаандаа явагдаж байгаа 37 буюу 13,3% байна.

2016 оны эхний 11-р сард дүүргийн Засаг даргын 43 удаагийн захирамжаар нийт 1718 иргэн, 34 аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Зориулалт	Газрын хэмжээ өөрчлөх	Газар эзэмших эрхийг сэргээх	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар эзэмших эрхийг баталгаажуулах	Газрын байршил өөрчлөх	Газар эзэмших хугацаа сунгах
Иргэн, ААНБ-ын тоо	2	1	409	2	855	3	4

[www.nso.mn](http://www.nso.mn)  
[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)  
[www.nad.ub.gov.mn](http://www.nad.ub.gov.mn)  
 Умас: 70233672